3. Төсөл захиалагчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийхийг үүрэг болгож байна.
4. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол Улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.
5. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ЭБМЗ-өөс даалгаж байна.
6. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үндэслэлийн тодотголыг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Цариг ресурс" ХХК, мөн ТЭЗҮ-ийн тодотголын үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын мэргэшсэн инженер Г.Батзаяа тус тус хариуцна.

Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХЗОРИГ

“Цариг шонхор” ХХК-ийн Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт ори хэсгийн алтны үүсмэл болон шороон ордыг ил аргаар ашиглах техник-з

Блоктын дугаар	Геологийн нөөц								Уурхайн хүрээгээр хаягдах нөөц			
	Блоктын талбай /мян.м ² /	Хөрсний зузаан /м/	Элсний зузаан/м ³ /	Хөрс эзлэхүүн /мян.м ³ /	Элсний эзлэхүүн /мян.м ³ /	Дундаж агуулга /шлик/ гр/м ³ /	Металлын нөөц /Шлик/ /кг/	Металлын нөөц /хими цэвэр/ /кг/	Дундаж агуулга /шлик/ гр/м ³ /	Элсний эзлэхүүн /мян.м ³ /	Металлын нөөц /Шлик/ /кг/	Металлын нөөц /хими цэвэр/ /кг/
В-1	12.54	2.98	0.83	37.41	10.41	0.300	3.13	2.62	0.301	0.15	0.05	0.04
В-2	9.96	3.02	0.78	30.06	7.76	0.311	2.42	2.03	0.311	0.21	0.07	0.06
В-3	7.98	3.09	0.69	24.63	5.51	0.282	1.55	1.3	0.282	0.2	0.06	0.05
С-1	1.82	3	0.8	5.45	1.45	0.280	0.41	0.34	0.281	0.02	0.01	0.01
С-2	3.38	3.07	0.73	10.36	2.47	0.266	0.66	0.55	0.267	0.18	0.05	0.04
Нийт В	30.48			92.1	23.68	0.300	7.1	5.95	0.298	0.57	0.17	0.14
Нийт С	5.19			15.81	3.92	0.272	1.07	0.89	0.268	0.2	0.05	0.04
Нийт (В+С)	35.67			107.91	27.6	0.296	8.17	6.84	0.29	0.77	0.22	0.19
Ерте												
С-1	2.07	0.48	3.68	0.99	7.6	0.072	0.55	0.46				
С-2	16.88	0.54	3.66	9.11	61.76	0.073	4.52	3.79	0.073	1.1	0.08	0.07
С-3	7.11	0.6	3.64	4.27	25.88	0.074	1.92	1.61	0.074	1.3	0.1	0.08
Нийт С	26.05			14.37	95.25	0.073	6.99	5.86	0.074	2.39	0.18	0.15
Бүгд В	30.48			92.1	23.68	0.30	7.1	5.95	0.298	0.57	0.17	0.14
Бүгд С	31.25			30.18	59.16	0.081	8.05	6.75	0.089	2.59	0.23	0.19
Бүгд (В+С)	61.72	3.03	0.75	122.28	122.84	0.123	15.16	12.7	0.126	3.16	0.4	0.33

2021 оны 12 дугаар сарын 01 ны өдрийн ХХ-14-02 тоот ЭБМЗ-ийн дүгнэлт, 2022 о орд тул уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадласан В' үйлдвэрлэлийн нөөц нь Өртөнт хэсгийн В-1, В-2, В-3, С-2, С-1 блокууд тусгай зөвшөөрлийн хилд урд б зөвшөөрлийн хилд тулсан байгаа нь уурхайн хажуу хананд батлагдсан нөөцөөс зайлшгүй)

Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны үүсмэл болон шороон ордод хаягдалгүй ац ул чулуулгаас мөн 0.1 м зузаан үеийг элстэй цуг олборлолтонд хамруулахаар тооцсон. Мөн Иймээс ордыг ашиглалтын үед хаягдалгүй олборлоно.

Үзүүлэлт гаргасан:

“Цариг Ресурс” ХХК-ийн
Уулын инженер:  / А.Эрдэнэбулг



ЭБМЗ-ийн 2022-07-04 дүгээр дүгнэлтийн хавсралт

их MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь Өртөнтийн урд дэнжийн дийн засгийн үндэслэлийн тодотголын үйлдвэрлэлийн нөөцийн нэгдсэн хүснэгт

Ашиглалтын нөөц					Бохирдол			Үйлдвэрлэлийн нөөц					
Хөрс эзлэхүүн /мян.м ³ /	Элсний эзлэхүүн /мян.м ³ /	Дундаж агуулга /шлих/ гр/м ³	Металлын нөөц /Шлих/ /кг/	Металлын нөөц /хими цэврэр/ /кг/	Бохирдолын хувь	Бохирдуулагч чулуулаг /мян.м ³ /	Блокчийн дугаар	Бортоор нэмэгдэх хөрс /мян.м ³ /	Хөрс эзлэхүүн /мян.м ³ /	Элсний эзлэхүүн /мян.м ³ /	Дундаж агуулга /шлих/ гр/м ³	Металлын нөөц /Шлих/ /кг/	Металлын нөөц /хими цэврэр/ /кг/
Өртөнт													
36.86	10.25	0.301	3.08	2.58	24.38	2.5	В'	3.2	38.82	12.75	0.242	3.08	2.53
29.24	7.55	0.311	2.35	1.97	26.08	1.97	В'	4.11	32.38	9.52	0.247	2.35	1.97
23.73	5.31	0.282	1.5	1.25	29.56	1.57	В'	4.76	27.72	6.87	0.218	1.5	1.25
5.36	1.43	0.281	0.4	0.34	25.51	0.36	В'	0.86	6.05	1.8	0.224	0.4	0.34
9.62	2.29	0.267	0.61	0.51	28.42	0.65	В'	3.33	12.64	2.94	0.208	0.61	0.51
89.83	23.11	0.3	6.93	5.81	26.13	6.04	В'	12.07	98.92	29.15	0.238	6.93	5.81
14.99	3.72	0.272	1.01	0.85	27.3	1.02	В'	4.19	18.68	4.74	0.214	1.01	0.85
104.81	26.83	0.296	7.94	6.66	26.29	7.05	В'	16.26	117.6	33.89	0.234	7.94	6.66
нт үүсмэлийн орд													
0.99	7.6	0.072	0.55	0.46	9.15	0.7	В'	0.04	0.82	8.3	0.066	0.55	0.46
8.95	60.67	0.073	4.44	3.72	6.23	3.78	В'	0.08	7.38	64.45	0.069	4.44	3.72
4.05	24.58	0.074	1.82	1.53	6.74	1.66	В'	0.07	3.45	26.24	0.069	1.82	1.53
13.99	92.85	0.073	6.81	5.71	6.61	6.13	В'	0.19	11.65	98.99	0.069	6.81	5.71
89.83	23.11	0.3	6.93	5.81	26.13	6.04	В'	12.07	98.92	29.15	0.238	6.93	5.81
28.98	96.57	0.081	7.82	6.56	7.4	7.15	В'	4.38	30.33	103.72	0.075	7.82	6.56
118.81	119.69	0.123	14.76	12.37	11.02	13.19	В'	16.45	129.25	132.87	0.111	14.76	12.37

ны 01-р сарын 06-ний өдрийн Н-03 тоот тушаалаар батлагдсан нөөцийн дүгнэлтэд Орд нь III бүлгийн 2-р бүлгийн 4-р зүйлд заасны дагуу бодитой В болон боломжтой С зэрэглэлийн нөөцийг магадласан 132.87 мян.м³ элс букуу хими цэврээр 12.37 кг алт болж байна. /Шлихээр 14.76 кг/. элон зүүн талаараа, Өртөнтийн үүсмэл ордын хэсгийн С-3, С-2, блокууд баруун талаараа тусгай аягдал үүсэх нөхцлийг бүрдүүлж байна.

иглалт явуулахын тулд алттай элсний давхаргаас дээш орших хучаас хөрсөнд 0.1 м зузаан үе үлдээх, уурхайн хажуугаас элсийг бохирдуулахаар тооцсон бөгөөд эдгээр үеүд бохирдуулагч чулуулаг болно.

Танилцсан:

ан /

АМГТГ-ын ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, бүртгэл хариуцсан мэргэжилтэн: / Ц.Золзаяа /

15/07/2022

*Ажлын эхний өсгөөн
08.00 20/07
Ч. Золзаяа 2022*



"ЭМ ЭС БЭЛ МАЙНИНГ" ХХК-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2023 01 24 № 13/450
танай _____ -ны № _____ -Т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай компаниас боловсруулан ирүүлсэн Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй Өртөнт /MV-000436/ тоот тусгай зөвшөөрөл бүхий "Алтны үүсмэл шороон орд" төсөлд "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Засгийн газрын 2013 оны "Журам батлах тухай" 374 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулан 2023 оны 2 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт... хуудастай

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Г.ЭНХМӨНХ

152370378

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС

2023 оны 01-р сарын 17

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2023/Е11

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "Эм эс бэл майнинг" ХХК, /РД: 6862578, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 4-р хороо, арцатын ам,

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 976-86045566

Төслийн нэр: "Алтны үүсмэл шороон орд"

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Өвархангай аймгийн Зүүнбаян-Улаан сум

Орон нутгийн санал: Өвархангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Засаг Даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 1/160 тоот санал, Е-Монголиа О99-2212-000073 дугаар хүсэлт, 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн нэмэлт материалыг тус тус үндэслэв.

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт			Тийм	
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг			Тийм	

	нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
	Хөрсөн бүрхэвч				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
	Ургамлан нөмрөг				
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
	Амьтны аймаг				
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм	
Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм		
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх	Тийм			
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм	

Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм	
Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм	
Түүх, соёлын биет өв				
Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм	
Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм	

Нэгдсэн дүгнэлт:

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу хийлгэн, нарийвчилсан үнэлгээний тайланг тус яаманд 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлж, шүүмж хийлгэн, шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзлээ.

Онцгойлон анхаарах зүйлс:



1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Байгаль орчны сайдын 2010 оны 156 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал"-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, ус, амьтан, агаар орчинд учруулах, учирсан хохирлыг байгалийн бүрэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар хохирлын хэмжээг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг цаашид хэрэгжүүлэх тохиолдолд байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодорхойлж дүгнэлт гаргах;
2. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах, дээрх хуулийн хэрэгжилт хангагдсан эсэхэд дүгнэлт боловсруулах;
3. Төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлыг хэмжээ, түүний тархалт, нөлөөллийн хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;
4. Хөрсний элэгдэл, эвдрэлийн өнөөгийн байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагаанаас үүдэн бий болж болзошгүй сөрөг нөлөөлөл түүнээс сэргийлэх болон нөлөөллийг багасгах арга хэмжээ түүнд шаардагдах хөрөнгө зардлыг нарийвчлан тооцох;
5. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал болон ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, материалаас гарах тусгай ангиллын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, устгах, зайлуулах аргыг нарийвчлан тооцож, төслийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгон хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр устгах, зайлуулах талаар зөвлөмж боловсруулах, бүлэг болгон тайланд тусгах;
6. Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрсөнд үүсэх бохирдлыг нарийвчлан тооцож, түүнийг арилгах, бууруулах талаар зөвлөмж боловсруулж, байгаль орчны бохирдол багатай техник, технологийн сонголт хийх;
7. Төсөл хэрэгжиж буй газар нутагт амьдарч буй иргэд, сумын удирдлагуудтай хамтран ажиллах, төслийн үйл ажиллагааны цар хүрээ, байгаль орчинд халгүй аргаар нийгэм, эдийн засаг, орон нутгийн хөгжилд үзүүлэх давуу болон сул талыг дэлгэрэнгүй танилцуулж, тэдний саналыг албан ёсоор авах, БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих багийн ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсаргах;

8. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгаалал, төслөөс шууд болон шууд бусаар хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг тооцож, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх зөвлөмж боловсруулах;
9. Төсөл хэрэгжиж буй газар нутгийн нөлөөллийн бүсийг тогтоож, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх болон байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээг тодорхойлон судалгаа хийж дүгнэлт боловсруулах;
10. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн цаг агаарын өөрчлөлтийг тодорхойлж газрын бүрхэвч, гадаргад нөлөөлөх нөлөөлөл, гадаргын ус болон гүний усанд төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг тодорхойлох, түүнийг багасгах арилгах арга зам, шаардагдах хөрөнгө зардлыг тогтоох;
11. Төсөлтэй холбоотой батлагдсан ТЭЗҮ, хориглосон, хязгаарласан бүс нутагт хамаарагдаж байгаа эсэх талаар лавлагаа, мэдээллийг холбогдох газраас авах, суурь судалгаагаар тогтоогдсон нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөө гарган тайланд хавсаргах;
12. Төслийн үйл ажиллагааны явцад унд ахуйд ашиглаж буй цэвэр усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан, түүнээс гарах ахуйн бохир усыг тус тус нарийвчилан тооцож тайланд тусгах;
13. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум модны үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн хүрээнд жишиг ногоон байгууламжтай байхаар төлөвлөн тайланд тусгах;
14. Төслийн холбогдох стандартын шаардлагыг хангуулах талаар дүгнэлт боловсруулж, тайланд хавсаргах;
15. Төсөлд ашиглах түүхий эдийн нийлүүлэлтийн талаар нарийвчлан судалж үнэлгээний тайланд тусгах, холбогдох хууль, тогтоомж болон зөвшөөрөл олгосон тухай баримт бичгийг тайланд хавсаргах;
16. Төслийн үйл ажиллагаа дууссаны дараах нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгааллын зардлыг тооцож мониторинг хийх, /дүйцүүлэн хамгааллын үйл ажиллагаа бодит хэрэгжихүйц байхад анхаарах/, хаалтын ажлын каледарчилсан төлөвлөгөө, зардлын тооцоог тус тус урьдчилан тооцож тайланд тусгах;
17. Төслийн ерөнхий дэвсгэр зургийг гаргаж, ОХШХөтөлбөрийг хэрэгжүүлэх цэгүүдийн байршил, 5 жилд олборлолт хийх төлөвлөлтийг тайланд тусгах;
18. Төслийн ТЭЗҮ болон ашиглах талбайтай уялдуулан экологи, эдийн засгийн хохирлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар боловсруулж тайланд хавсаргах;
19. Төслийн талбайд Газрын төлөв байдлын чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байхыг тайланд тусгах;

Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн дагуу хариуцлага тооцохыг урьдчилан мэдэгдье.

Бусад зүйлс:

1. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны хяналтын байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг цаг тухай бүрт нь ханган биелүүлж байх;
2. Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг биелүүлэх талаар байгаль орчин, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай байнга хамтран ажиллах;
3. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;
4. Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, нөхцөл, болзолос өөр үйл ажиллагаа явуулах болон төсөлд өөрчлөлт орох, эсхүл өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх;

<p>Ерөнхий үнэлгээ хийсэн:</p> <p>Албан тушаал: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээч</p> <p>Овог, нэр: Н.Эрдэнэчимэг</p> <p>Гарын үсэг: </p> <p>Огноо: 2023.01.17</p>	<p>Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:</p> <p>Албан тушаал: "Эм эс бэл майнинг" ХХК-ний захирал</p> <p>Овог, нэр: Б.Цолмонбаатар</p> <p>Гарын үсэг: </p> <p>Огноо: 2023.01.17</p>
---	---





МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 19 66, Цахим шуудан: contact@mecc.gov.mn,
Цахим хуудас: www.mecc.gov.mn

2025.07.03 № 05/3408

танай _____-ны № _____-т

"ЭМ ЭС БЭЛ МАЙНИНГ" ХХК-д

Танай компаниас ирүүлсэн албан бичигт дурдсан Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөр бүхий "Өртөнт, нарийн жалга" нэртэй алтны шороон ордын төслийн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2023, 2024, 2025 онд батлуулж 2023, 2024 онд тайлан хянуулсан байна.

Мөн Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн 9.10.-т "Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ." гэж заасны дагуу 2023 онд 7.576.000 төгрөг, 2024 онд 8.576.000 төгрөг, 2025 онд 8.576.000 төгрөг төвлөрүүлсэн байна.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Г.ЭНХМӨНХ

1525002257



ЭКО ЭКСПРЕСС ХХК-Д

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Барилгачдын талбай 3, Утас: 26 02 03,

Факс: (976-11) 32 26 83, И-мэйл: info@gazar.gov.mn

2023.07.26 № 3/1572
танай 2023.07.18-ны № 18/24 -Т

Дүгнэлт баталгаажуулсан тухай

Газрын тухай хуулийн 58 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн Газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам"-ын 3.5 дахь хэсэгт заасны дагуу танай байгууллагын Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших MV-000436 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 40.64 га талбайд гүйцэтгэсэн газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын дүгнэлтийг баталгаажуулан хүргүүлэв.

Хавсралт ⁵ хуудастай.

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.ИХБАЯР

1523032108

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хянан баталгааны төрөл: Захиалгат

Огноо: 2023.07.26

1. Газар ашиглагч: "Эм Эс Бэл майнинг" ХХК

2. Аймаг: Өвөрхангай

Сум: Зүүнбаян-Улаан

3. Газар ашиглалтын төрөл: Уурхайн талбай

4. Байршил, хаяг: Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум, 1-р баг

5. Нэгж талбарын дугаар: 62120-Эм Эс Бэл майнинг

6. Хөрсний код, нэр: 1502, Уулын хүрэн хөрс

7. Ургамалжилт: Н-III-3-2 Дэрс-хиаг-алаг өвст, У-III-2-11 Жижиг-дэгнүүлт үетэн-алаг өвст

8. Нэгж талбарын хэмжээ: 40.64 га

9. Газар эзэмших зориулалт:

10. Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Уурхайн ашиглалтын талбай

11. Газар ашиглах, эзэмших шийдвэр: Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын 2007 оны MV-000436 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл, Кадастрын хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 95 дугаар шийдвэр

12. Эзэмших газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт:

Газар ашиглалтын төрөл	Талбай, /га/	Бохирдлын төрөл		
		Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшил газар	40.64	-	-	-
Нэгж талбарын талбай	40.64	-	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	-	-	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай	40.64	-	-	-
1.Үйл ажиллагаанд өртөөгүй	14	+	-	-
2.Үйл ажиллагаанд өртсөн	26.4	+	-	-
Тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд эвдэрсэн газар /талбайн урд/	5	+	-	-
Мэдээллийн сангийн тооллогоор талбайн дотор эвдэрсэн газар /талбайн урд/	10	+	-	-
Тусгай зөвшөөрлийн гадна эвдэрсэн талбай /талбайн баруун/	18	+	-	-
Мэдээллийн сангийн тооллогоор нийт эвдэрсэн газар /талбайн урд болон баруун/	11.6	+	-	-

Газрын гадарга, төлөв байдал: "Өртөнт Нарийн жалга" –ын алтны үүсмэл шороон орд газар нь Хангай ар говийн мужуудын тал хээрийн бүсэд хамаарагдана. Зүүн хойд хэсгээр нь далайн төвшингөөс дээш 2300-2400 метр хүртэл өндөр 15-18 км хүртэл урт Хараат-Ширээт нуруу үргэлжилнэ. Өртөнтийн амны газрын дундаж өндөр 1920-2100 м (д.т.д) орчим, хамгийн нам цэг Өвтийн гол 1950 м д.т.д Уулсын орой нь

тэгшивтэр хад, асга ихтэй, ар хажуугаараа хар модон ой голлон зонхилно. Уулсын өвөр хажуу нь модгүй, алаг өвс-үетэнт ургамал зонхилсон уулын хээр, уулын нугат-хээртэй. Жижиг голын дагуу алаг өвс-улалжит нугын ургамалшилтай. Уулзүйн тогтоцоор Хангайн уулархаг өндөрлөгийн зүүн хэсэгт багтана. Өртөнтийн ам нь шивээтийн нуруунаас эх авах ба баруун урагшаа чиглэлтэйгээр баруун голд (нутгийн хүмүүсийн нэрлэдгээр, өвтийн гол) нь онги голтой нийлж Онги голын усзүйн сүлжээнд багтана. Өртөнтийн амны баруун хажуу нь урд нурагийн уул, зүүн хажуу нь өртөнтийн адгийн толгой, өртөнтийн адгийн толгой нь Нарийн жалгын амны баруун хажуу, зүүн хажуу нь хүрэнгийн нуруугаар зааглагдана. Уулс нь хавтгай бөмбгөрдүү оройтой, бэсрэг уулсын шинжтэй. Харин ширээтийн нуруу нь харьцангуй шовх оройтой, дунд зэргийн өндөршилтэй, хадан гарш, жалга сайр элбэгтэй, эгц хажуутай. Судалгаа явуулсан талбай нь бүс нутгийн хувьд Хангайн салбар уулархаг өндөрлөгийн зүүн өмнөд хэсэгт байрлана.

13. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл: Нэгж талбарын хөрсний бүтэц талбайн урд хэсэгт эвдэрч талхлагдсан, байгалийн унаган төрх алдагдсан байна. Хөрсний шинж чанар, ерөнхий үзүүлэлт, бохирдлыг тодорхойлох зорилгоор 3 цэгээс агрохимийн дээж авч шинжлүүлэв. Машин техник бага явсан, хог хаягдалгүй байсан бөгөөд хөрсний хүнд металлын дээж 2, эрүүл ахуйн шинжилгээ 1 авч шинжлүүлэв. Хөрсөн бүрхэвчийн хувьд уулын хүрэн хөрс тархсан байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлт дугаар	Гүн, см	Механик ширхэгүүд (%), ширхэгийн хэмжээ (мм)						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж -1	0-20	14.6	44.6	20.7	4.5	6.4	9.2	20.1
Дээж -2	0-20	14.5	46.5	15.9	6.8	7.7	8.7	23.2
Дээж-3	0.20	7.0	52.3	18.5	8.6	8.3	5.2	22.1

Хөрсний шинжилгээний дүнгээр физик шаврын хэмжээгээр дээж- 1,2,3 нь хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний агрохимийн шинж чанар

Зүсэлтийн дугаар	Гүн, см	pH	Давс, (%)	ЦДЧ, dS/m	Ялзмаг (%)	CaCO ₃ (%)	NO ₃ , мг/100гр	Шим тэжээлийн элементүүд, мг-экв/100 гр		Үржил шимийн элемент мг/100гр	
								Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
Дээж -1	20	8.22	0.044	0.104	2.50	0.96	0.33	27	5	1.4	25
Дээж -2	20	8.00	0.047	0.111	2.95	0.0	0.29	18	9	2.6	24
Дээж-3	20	7.69	0.013	0.031	3.74	0.0	0.11	24	14	1.5	28

Хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой 2,3-р дээж, дээж-1 дунд зэрэг шүлтлэг дээжний өнгөн үе давхаргад карбонат илрээгүй байна. 1,2,3-р дээж ялзмагийн дунд агууламжтай, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор бага хангамжтай, хөдөлгөөнт калийн хангамжаар дунд зэрэг байна. Солилцох сууриудын нийлбэр 27-38 мг-экв/100г байгаа нь дунд байна.

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээжний нэр	Агууламж мг/кг

	Ni /никель/	Cd /кадми/	Pb /хар тугалга/	Zn /цайр/	Cr /хром/	Cu /зэс/
Дээж-1	36.9	0.0	20	94.7	19.1	17.6
Дээж-2	51.3	0.0	12.5	92.1	21.5	19.5
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ/MNS5850:2019/						
Шавранцар хөрс	100	1.5	70	150	100	80
Элсэрхэг хөрс	60	1	50	100	60	60
Шаварлаг хөрс	150	3	100	300	150	100

Задлан шинжилгээний дүнгээс үзэхэд Монгол улсын стандарт хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүнг "MNS 5850:2019" стандарттай харьцуулахад хөрсний бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээ буюу хортой агууламжаас бага гарсан тул хөрс бохирдолгүй гэж үзэж байна.

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ, 1 гр хөрсөнд

Дээж дугаар	Нянгийн тоо MNS 6341:2012	Гэдэсний савханцрын титр MNS 5367:2004			Перфрингенсийн таньц MNS 6341:2012	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	
Дээж-3	8.8*10 ⁵	1	1	0.1<	1	

Микробиологийн шинжилгээний үр дүнг "MNS 3297:2019" стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байгаа тул хөрс бохирдолгүй байна.

15. Ургамлын нөмрөгийн төрх байдал, доройтлын зэрэглэл: Төслийн талбайд үетэн-алаг өвст ургамлан бүлгэмдэл тархсан байна. Тус газарт крыловын хялгана (*S. krylovii*), Дэрс-Хиаг-Алаг өвст, Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст дэрвээн хазаар өвс (*Cleistogenes squarrosa*) зонхилж, мөлхөө хиаг (*Agropyron repens.*) зонхилж, саман ерхөг (*Agropyron cristatum*), сунагар биелэг (*Poa attenuate*), зогдор улалж (*Carex pediformis*), агь (*Artemisia frigida*), нарийн навчит халгай (*Urtica angustifolia*), таван салаа (*Plantago major*), ишгүй гичгэнэ (*Potentilla acualis*), галуун гичгэнэ (*Potentilla anserina*) болон шүлхий шарилж (*Artemisia pectianata*), ямаан шарилж (*Artemisia scoparia*), шоргор лууль (*Chenopodium acuminatum*) зэрэг ургана. Ургамлын дундаж өндөр 15 см, ургамлын тусгаг бүрхэц 50-80%, халцгай газрын хэмжээ 10-20% байна. 100м² талбайд зүйлийн бүрэлдэхүүний тоо 10-20 ш байна.

Ургамлан нөмрөгийн төлөв байдал

№	Бэлчээрийн хэв шинж	Ургамлан бүрхэвчийн төлөв байдал							
		Ургамлын бүрхэц, %		Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Талхлагдлын зэрэг	Халцгай газар	Хад чулууны хэмжээ	Ургач, ц/га
		1м ² талбайд	100 м ² талбайд	1м ² талбайд	100 м ² талбайд				
1	Дэрс-Хиаг- Алаг өвст-	50-60%	40-50%	4-6	10-15	Бага	10-20	5	10
2	Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст	70-80%	75-80%	5-9	10-20	Бага	10-20	5	10

16. Газар ашиглалтын зөрчил, аюулгүй байдал: Өндөр хүчдэл гуу жалга, үерийн ам гал зэрэг газар ашиглалтын аюулгүй байдал зөрчигдөөгүй. Нийт эдэлбэр газарт ашиглалт явагдаж эхлэх гэж байна. Тусгай зөвшөөрөл авахаас өмнөх хууль бусаар

олборлолт явагдаж ухагдсан талбай тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд 5 га талбай байна. Ухагдсан талбай нь байгалийн жамаар өөрөө эдэгдэж ургамал ургасан. Өөр элэгдэж эвдэрсэн талбай болон илүү ашиглаж буй талбай байхгүй. Хот тосгон бусад суурин газраас 22 км зайтай байна.

17. Газар ашиглалтын талаар цаашид авах арга хэмжээ, дүгнэлт, зөвлөмж:

Газрын элэгдэл эвдрэлийн хувьд тусгай зөвшөөрлийн талбайн хүрээнд нийт эзэмшил газрын 40.64 га хэмжээнээс талбайн дотор талд нийт 15 га хэмжээтэй талбай эвдэрсэн. Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн эвдэрсэн газрын тооллогоор Өртөнтийн уурхай дээр 11.6 га хэмжээтэй эвдэрсэн гэж бүртгэгдсэн. Үүнээс талбайн дотор 10 га, талбайн гадна 1.6 га эвдэрсэн байна. Газар дээрээ очиход нүдэн баримжаагаар уулруугаа ороогүй байна. Тооллогын шэйф файлаас харахад талбайн зүүн талын уулруугаа орсон харагдаж байгаа нь бодит байдлаас зөрүүтэй байна. Энэхүү талбайд "Эм Эс Бэл майнинг" ХХК тусгай зөвшөөрөл авахаас өмнө гар аргаар алт олборлодог хүмүүс хууль бусаар олборлолт явуулж тусгай зөвшөөрлийн талбайн урд хэсэгт эвдрэлд өртсөн. Нийт тусгай зөвшөөрлийн талбайн гадна талын эвдрэлийн хэмжээ нь 19.6 га байна.

Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэснээр дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгч нь БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/138 дугаар тушаалаар батлагдсан "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"-ын дагуу нөхөн сэргээлт хийх,
- Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтаар авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах,
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах,
- Ордын талбайд олон салаа зам үүсгэхээс аль болох зайлсхийж, замын тэмдэглэгээ хийх, орц гарцыг нэгдсэн байдлаар шийдэх, засварлах талбайг тусад нь засаж хайрган хучилттай болгох
- Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг Монгол улсын хэмжээнд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журам, стандартын дагуу мөрдөж ажиллах,
- Хог хаягдлыг ахуйн болон аюултай хогоор нь ялган хог хаягдлын нэгдсэн цэгт хаях, цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулахдаа "Хог хаягдлын тухайн хууль"-ийн 10, 14, 15-р бүлэгт заасан заалтуудыг мөрдөх,
- Хөрс хамгаалах агротехник, ойн зурвас, ногоон байгууламж бий болгох, микро гадаргуу үүсгэх аргуудын хэрэгжилтэд хяналт тавих,
- Уурхайн ухагдсан талбайг тойруулан тор татах, хүн амьтан унаж бэртэхээс сэргийлэх,
- Ашиглалтын ажлын үед хэрэглэгдэж байгаа машин, механизмуудын дотоод шаталтат хөдөлгүүрийн яндангаас гарах утаа, хорт хий агаар

орчныг бохирдуулах эх үүсвэр байгаа тул хүнд даацын машин, механизмын дотоод шаталтат хөдөлгүүрийн янданд шүүлтүүр тавьж жил бүрийн техникийн үзлэгээр утаан дахь хорт хийн агууламжийг хянуулах, засвар үйлчилгээг тогтмол хийж байх,

- Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу газар ашиглагч, өмчлөгч иргэн, аж ахуйн нэгж нь 5 жил тутамд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг өөрийн хөрөнгөөр гаргуулан ажиллах
- Газар эзэмших эрхийн хүсэлтээ өгсний дагуу газрын бичиг баримтын бүрдэл болох гэрээ, гэрчилгээ, кадастр гаргуулах шаардлагатай.

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
УЛСЫН ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж. БАТСАЙХАН - 2

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 09-р сарын 26-ны өдөр

№ EA-2025/12

Улаанбаатар хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г нэг талаас 6082386 тоот регистрийн дугаартай Байгаль орчны аудитын (БОА) "Аглиш" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх), түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Э.Солонго, нөгөө талаас 6862578 тоот регистрийн дугаартай "Эм Эс бэл майнинг" ХХК (цаашид "Захиалагч тал" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Тогооч нар Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ гэрээгээр Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт байрлах MV- 000436 Өртөнтийн алтны үүсмэл болон шороон ордын үйл ажиллагаанд БОА хийх, БОА-ын тайланг боловсруулж, хүлээлгэн өгөх, гэрээний төлбөр төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. **Гэрээний хугацаа:** БОА-ын баг газар дээрх үзлэг зохион байгуулснаас хойш 30-40 хоногт БОА-ын тайланг гүйцэтгэгч талд танилцуулахаар өгсөн байна.
- 1.3. **Гэрээний үнэ:** 10 000 000 ₮ (сая) төгрөг.
- 1.4. Энэ удаагийн БОА-ын хамрах хүрээнд дараах үндсэн чиглэлүүд багтана. Үүнд:
 - ✓ Байгаль орчны удирдлагын тогтолцоо
 - ✓ Агаарын чанар
 - ✓ Ус ашиглалт
 - ✓ Газар ашиглалт, хөрсний чанар
 - ✓ Хог хаягдлын менежмент
- 1.5. **Гэрээний үр дүн:** Гүйцэтгэгч Байгаль орчны аудит хийх, Байгаль орчны аудитын тайланг хэвлэмэл 2%, мөн файл хэлбэрээр захиалагчид хүлээлгэн өгнө.

ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Захиалагч нь гэрээт ажлыг хамтран зохион байгуулах, төслийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй үнэн зөв мэдээлэл өгөх ба аудитын ажлыг гүйцэтгэх, аюулгүй ажиллах шаардлагатай орчин, нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.2. Захиалагч нь гүйцэтгэгчийн ажлын явцтай танилцах, шаардлагатай тохиолдолд аудитын дүгнэлтийг сайжруулахыг шаардах эрхтэй.
- 2.3. Захиалагч нь БОА-ын баг газар дээрх үзлэгээ гүйцэтгэхэд шаардлагатай нэг бүрийн хувийн хамгаалах хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, бусад хэрэгслэлээр хангах зааварчилгаа өгч болно.
- 2.4. Ахлах аудиторгоор дамжуулан БОА-ын багт санал, хүсэлт, шаардлагаа хүрүүлнэ.
- 2.5. Захиалагч талаас БОА-ын үйл ажиллагааг хамтран зохион байгуулах, аудитын тайлан, үр дүнг хүлээн авах эрх бүхий албан тушаалтанг томилсон байна.
- 2.6. Энэ гэрээний 2.5-д заасан албан тушаалтан БОА-ын багийг шаардлагатай мэдээллээр шуурхай хангах, газар дээрх үзлэгийг богино хугацаанд оновчтой хэрэгжүүлэх, гэрэл зураг авах, тэмдэглэл үйлдэх, ярилцлага хийх нөхцөлөөр хангаж, дэмжлэг үзүүлнэ.
- 2.7. БОА-ын газар дээрх үзлэгийн үед аливаа хязгаарлалт, түсгэй нөхцөл байдал бий болсон үед Ахлах аудитор яаралтай мэдээлнэ.
- 2.8. Аудитын гэрээт ажлын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд саадгүй шилжүүлнэ.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Хөндлөнгийн, бие даасан, хараат бус, нотолгоонд түшиглэсэн БОА-ыг гүйцэтгэж, БОА-ын тайлан боловсруулж, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх

- сөрөг нөлөө, үр дагавар, хамрах хүрээ, учирч болзошгүй аливаа осол, эрсдэл, хохирлыг тодорхойлох, илэрсэн зөрчил, үл нийцлийг арилгах, зардал хэмнэх үр ашигтай менежмент, хэрхэн урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж өгнө.
- 3.2. БОА-ыг хариуцлагатай гүйцэтгэж, төслийн эзэмшил талбайд нэвтэрч, ойр орчинд нь ажиглалт хийх, барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй танилцах, баримт бичгийн аудит хийх, гэрэл зураг авах, хариуцсан удирдлага, мэргэжилтэнтэй ярилцлага хийх болон илэрсэн асуудлуудыг нэгтгэх явцад аудит хийлгэгч буюу Захиалагч байгууллагын соёл, дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг хүндэтгэн эн тэргүүнд дагаж мөрдөж ажиллана.
- 3.3. Гүйцэтгэгч БОА-ын зорилго, хөтөлбөр, удирдамжийн дагуу мэргэжлийн байх, нягт нямбай байх, үл ялгаварлах, ашиг сонирхлын зөрчилгүй байх, гуравдагч талуудтай мэдээллийг хэлэлцэхгүй байх, буруу болон төөрөгдөл үүсгэхгүй байх, нотолгоонд түлгүүрлах зарчмуудыг эрхэмлэн ажиллана.
- 3.4. БОА хийхэд шаардлагатай мэдээлэл гаргуулах, газар дээрх үзлэгийн үед хувийн хамгаалах хэрэгсэл, зааварчилгаа шаардлагатай бол үг хүсэлтээ илэрхийлэх.
- 3.5. Захиалагчаас БОА-ын үед олж авсан мэдээлэл, дотоод журам, бичиг баримтыг актаар хүлээн авч, ажил үүргээ дуусмагц акт үйлдэн буцаан хүлээлгэн өгнө.
- 3.6. Захиалагч хүсвэл БОА-ын тайланд шаардлагатай сайжруулалт хийж болно.
- 3.7. Гэрээний үүргээ биечлэн гүйцэтгэх бөгөөд гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 3.8. Захиалагчийн нэр барих, түүнд мэдэгдэхгүй, зөвшөөрөлгүй орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн иргэн, аж ахуйн нэгжид аливаа мэдээлэл өгөхгүй байх.
- 3.9. Мэргэжлийн бус, эсвэл мэргэжлийнх мөртлөө түршлагагүй хүн ажиллуулахгүй.

ДӨРӨВ. АУДИТЫН ҮЕ ШАТ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

- 4.1. БОА-ыг гэрээний 1.5-д заасан хугацаанд дараах үе шатуудад хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.1.1. БОА-ын бэлтгэл үе шат:
- 4.1.2. БОА-ын газар дээрх үзлэгийн үе шат:
- 4.1.3. БОА-ын тайлан боловсруулах үе шат:
- 4.1.4. БОА-ын тайлангийн төслийг танилцуулах үе шат:
- 4.1.5. БОА-ын тайланг хүлээлгэж өгөх үе шат:

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА, БАТАЛГАА

- 5.1. БОА-ын үед илэрсэн зөрчил, болзошгүй эрсдэл, үр дагавар, урьдчилан сэргийлэх арга замыг гүйцэтгэгч БОА-ын тайланд тусгаагүй нь экологийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 5.2. Захиалагч гэрээний 2.1-д заасан мэдээлэлээр хангаагүй нь 5.1 дэх нөхцөл байдлыг үүсгэсэн бол гүйцэтгэгч хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.
- 5.3. Гүйцэтгэгч нь мэргэжлийн компанийн хувьд Захиалагчийн ажлыг гүйцэтгэх баг, аргачлалыг өөрөө сонгож, хэрэгжилтэнд баталгаа гаргана.
- 5.4. Талууд бичиг баримт солилцохдоо акт үйлдэн хүлээлцэх бөгөөд БОА-ын тайланг хүлээлцэхдээ буцаан өгч, хуулбар хувь үлдээгүй тухай баталгаа өгнө.
- 5.5. Гүйцэтгэгч талын ажлын гүйцэтгэл нь холбогдох стандарт заавар журам техникийн тодорхойлолтод нийцсэн байна.

ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 6.1. Гэрээний дагуу гүйцэтгэх ажлын нийт хөлс: 10 000 000 ₮ (Арван сая) төгрөг байна. Гэрээ хэрэгжих явцад энэхүү үнийн дүн өөрчлөгдөхгүй.
- 6.2. Захиалагч тал нь гэрээний 6.1-т заасан төлбөрийн 60%-ийг гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 3 хоногт, үлдэгдэл төлбөрийг ажил дуусаад ажлын үр дүнг актаар хүлээлгэн өгсөн

өдрөөс хойш 3 хоногт багтаан гүйцэтгэгч талын **660034** 104401883262 тоот Төрийн банк дансанд шилжүүлнэ.

- 6.3. Гэрээнд зааснаас өөр нэмэлт ажил гүйцэтгэх тохиолдолд холбогдох зардлыг харилцан тохиролцож, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна. Талууд энэ гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэнэ

ДОЛОО. ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

- 7.1. БОА-ын баг газар дээрх үзлэгийн үед Захиалагч талын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг чанд баримтлаж ажиллана.

НАЙМ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

- 8.1. Гүйцэтгэгч гэрээ байгуулснаас хойш энэ гэрээ болон төслийн талаарх мэдээллийг хугацаагүй хадгалах үүрэг хүлээнэ.
- 8.2. БОА-ын тайланг бичиг баримт солилцох акт үйлдэн хүлээлцсэн материалуудын хамт захиалагчид хүлээлгэн өгч, хуулбар хувь үлдээгүй тухай баталгаа өгнө.

ЕС. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 9.1. Гэрээний үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн саатуулсан, тасалдуулсан, хойшлуулсан, хүчтэй цасан болон шороон шуурга, газар хөдлөлт, үер зэрэг байгалийн гэнэтийн үзэгдэл, түймэр, нийтийг хамарсан халдварт өвчний улмаас хөл хорьсон, үймээн, эсэргүүцлийн жагсаал, төрийн байгууллага, орон нутгийн захиргааны шийдвэр, хоригийг Давагдашгүй хүчин зүйл гэж үзнэ.
- 9.2. Дараах тохиолдолд давагдашгүй хүчин зүйл гэж үзэхгүй. Үүнд:
- 9.2.1. Зардлын өсөлт, эдийн засгийн сөрөг нөлөө
- 9.2.2. Гэрээний үүрэг гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн техник, тоног төхөөрөмж, машин эвдрэх, алдагдах, түлш тасалдах зэрэг болно.
- 9.3. Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд нөгөө талдаа нэн даруй мэдэгдэх ба уг нөхцөл байдал арилах хүртэл гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаа түр хойшлоно.

АРАВ. БУСАД

- 10.1. Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 10.2. Талууд аливаа асуудал, үл ойлголцлыг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АГЬЛИШ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.СОЛОНГО

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

ЭМЭС БЭЛ МАЙНИНГ ХХК

МАЙНИНГ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ТОГООЧ



Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
5-р хороо, Ялалт плаза 903 тоот

Утас: 99058080, 99561680



Handwritten signature

Хаяг: Сүхбаатар аймаг Арвайхээр сум 5
баг Арвайхээр 232, 706 тоот

Утас: 88111018





МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар: 0160077
АГЬЛИШ ХХК

РЕГИСТРИЙН ДУГААР: 6475248

/Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар/

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10¹ дүгээр зүйлийн 4. дэх хэсэг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023. оны 11... дугаар сарын 10-ны өдрийн А/593. дугаар тушаалыг үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгалийн нөөц, баялагийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд байгаль орчны аудит хийх эрхийг гурван жилийн хугацаагаар олгов.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

 Б.БАТ-ЭРДЭНЭ

2023 оны 11. сарын 10-ны өдөр

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлтийн агуулга, сунгалт	Бүртгэх, сунгах тухай шийдвэр	
		он. сар. өдөр	Гарын үсэг /тамга/

Энэхүү гэрчилгээг хуулбарлах, олшруулахыг хориглоно.



Х.БАЛЖИННЯМ



НИЙМГИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2025 оны 06 дугаар сарын 20

№03

Зүүнбаян-Улаан сум

Энэхүү гэрээг нэг талаас Зүүнбаян-Улаан сумын Засаг дарга Х.Балжинням (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Эм эс бэл майнинг" ХХК-ийн захирал ажилтай Б.Тогооч (цаашид "Тусгай зөвшөөрөл эзэмшигч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Зүүнбаян-Улаан суманд байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээ нь Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Өртөнт гэх газарт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, ажлын байр нэмэгдүүлэх талаар сайн дурын дэмжлэг үзүүлнэ.

1.3 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй тухайн сумын Засаг дарга гэрээ байгуулна.

Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1 Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1 Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах,

2.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн, ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах,

2.1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих,

2.1.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх,

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.1 Үйл ажиллагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлын талаар зохих журмын дагуу Засаг дарга, ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх,

3.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах,

3.1.3 Нийт ажлын байрны 30-аас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах,

3.1.4 Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг сумын Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх,

3.1.5 Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоотухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох,

3.1.6 Орон нутгийн малчин иргэдээс 10 үхэр, 1 тооно сүү, цагаан эдээ худалдан авах,

3.1.7 Тусгай зөвшөөрөл бүхий талбай дээрээ тухайн жил ашигласан талбайд дотоод овоолгоор нөхөн дүүргэж техникийн нөхөн сэргээл хийнэ. Мөн урд нь бичил уурхайн үйл ажиллагааны улмаас болон гар аргаар ашигт малтмал олборлогчдын ухсан газарт техникийн нөхөн сэргээлт хийж ажиллана.

3.1.8 Зүүнбаян-Улаан сумын нэг дүгээр багийн нутаг дэвсгэр баруун голын Бамбахайн гарам дээр өөрийн хөрөнгөөр буюу 60.000.000 /жаран сая/ төгрөгөөр гүүр барих ажлыг хэрэгжүүлнэ.

3.1.9 Сумын төвийн хогийн цэгийг түрж янзалж, хогийн цэг ухаж өгөх ажилд 30.000.000 /гучин сая/ төгрөг зарцуулах

3.1.9 Багийн өдөрлөгийн үйл ажиллагаа болон багийн бусад үйл ажиллагааг дэмжиж оролцох

3.1.11 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах,

3.1.12 Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц суулгац худалдаж авахад 2.000.000 /хоёр сая/ төгрөг, тарихтай холбоотой арчилгаа, усалгаа, ажиллах

хүчинтэй холбоотой заралд 1.000.000 /нэг сая/ төгрөг, нийт 3.000.000 /гурван сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлэх,

3.1.13 Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын 450.000 /дөрвөн зуун тавин мянган/ төгрөг төрийн санд төвлөрүүлэх

3.1.12 Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, хэрэгсэл, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх,

Дөрөв. Гэрээний хугацаа

4.1 Гэрээний хугацаа нь гэрээг хоёр тал баталгаажуулсан өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

Тав. Хариуцлага

5.1 Гэрээ цуцалсан, дуусгавар болсонтой холбоотойгоор буруутай тал нөгөө талдаа учруулсан хохирол, гэм хор, зардлыг бүрэн хариуцаж арилгана.

Зургаа. Бусад зүйл

6.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

6.2 Гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлтийг талууд харилцан тохиролцож, бичгээр үйлдэн баталгаажуулна. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна. Гэрээний хавсралт №....., хуудас

6.3 Энэхүү гэрээнд тусгагдаагүй аливаа асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

6.4 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба зөвшилцөлд эс хүрвэл Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.5 Энэхүү гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдсэн ба бүх хувиуд хуулийн адил хүчинтэй бөгөөд талуудад тус бүр нэг хувь хадгалагдана.

Гэрээ байгуулсан:

Засаг даргыг төлөөлж:

.....
Гарны үсэг: 

Огноо: 2025.....

Хаяг: ЗБУ сум

Утас:

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж

Ч.Чинзориг

Гарын үсэг: 

Огноо: 2025.: 06.03.....

Хаяг: Арвайхээр сум

Утас: 89081177

ЗАРЛАГЫН БАРИМТ №

Алст

(Байгууллагын нэр)

ИнжБэлмийн

(Худалдан авагчийн нэр)

Регистрийн №

Регистрийн №

20.... оны сарын өдөр

(тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)

№	Материал үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэм- жих нэгж	Худалдах		
				Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	<i>Протиль төмөр</i>		<i>10</i>	<i>10</i>	<i>5000</i>	<i>50000</i>
2	<i>Алст төмөр Би</i>		<i>МКБ</i>	<i>27</i>	<i>100000</i>	<i>2700000</i>
3	<i>Талхуурт лектро</i>	<i>422</i>	<i>5000</i>	<i>10</i>	<i>20000</i>	<i>200000</i>
4	<i>" " "</i>	<i>507</i>	<i>" "</i>	<i>10</i>	<i>20000</i>	<i>200000</i>
5	<i>Илэрхий буудал</i>		<i>107</i>	<i>30</i>	<i>30000</i>	<i>900000</i>
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						
Дүн						4500000

Хүлээлгэн өгсөн эд хариуцагч: / /
Тэмдэг Хүлээн авагч: / /
 Шалгасан нягтлан бодогч: / /



Гүйлгээ амжилттай.

15,000,000.00 MNT

2025/10/05 15:46

Дансны үлдэгдэл



Хүлээн авагч

БОЛДПҮРЭВ УРАНМАНДАХ

MN98 000500 5048325315



Гүйлгээний утга

**ZBU sumand ovs Em Es bel maining
hkh's**

Загвар үалгалав

Дуусгах



УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот Утас:

оны -р сарын -ны
өдөр

Дугаар E-2503-000128

265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Эм Эс бэл майнинг ХХК
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 6862578
Захирал: Тогооч
Холбоо барих дугаар: 89298252
Факс :
Э-мэйл хаяг :

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Өртөнтийн алтны шороон болон үүсмэл орд
Байршил: Өвөрхангай, Зүүнбаян-Улаан, 1-р баг, Эмгэд
Харьяалагдах сав газар: Онги голын сав газар
Хамаарах салбар: Уул уурхай
Төслийн дэлгэрэнгүй: Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших "Өртөнтийн урд дэнжийн хэсэг" нэртэй 40.64 га талбай бүхий ашигт малтмалын MV-000436 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх 2007 оны 03-р сарын 28-ны өдөр "Гурван тамга" ХХК-д олгосон байна. Тус талбайн зарим хэсэг нь 2011 оны Засгийн газрын 174-р тогтоолын дагуу "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай" хуультай хэсэгчлэн давхцалтай байсан тул 2012 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн АМГ-ын 552 тоот шийдвэрээр тус талбайн давхцалтай 35.28 га газрыг хэсэгчлэн буцаан өгч, компанид үлдэх хэсэг нь MV-000436 (22.23 га) болон MV-017108 (9.45 га) тоот тусгай зөвшөөрлүүдэд хуваагдсан. Гэвч дээрх Засгийн газрын 174-р тогтоолоор баталсан хил зааг алдаатай байснаас тус MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ болон солбицолд оруулсан өөрчлөлт нь буруу хийгдсэн байсан. Иймээс компанийн зүгээс холбогдох байгууллагуудад хүсэлт гаргасаны дүнд 2019 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 374 тоот шийдвэрээр дээрх хуулийн давхцалгүй хэсэг болон MV-017108 тоот тусгай зөвшөөрлийн талбайг буцаан MV-000436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд нэгтгэн одоогийн

байдлаар 40.64 га талбайтай байгаа болно. Улмаар 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 174 тоот тушаалаар "Ирмүүн босго" ХХК-иас "Эм эс бэл майнинг" ХХК-д олгосон байна. "Эм эс бэл майнинг" ХХК-ийн MV-000436 тоот тусгай зөвшөөрлийн талбайд нэмэлт хайгуулын ажлыг хийж гүйцэтгэн, тайланг 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулан нөөц нэмэгдсэн, мөн 2013 оны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан. Өртөнтийн урд дэнжийн хэсгийн алтны шороон ордыг 2 жилийн хугацаанд, жилийн 133.0 мян.м3 элс олборлон баяжуулах хүчин чадалтайгаар үйл ажиллагаагаа явуулна. Хүснэгт №1.Тайланд авсан хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалт 2025 онд үлдэгдэл нөөц болох 60.49 мян.м3 элсийг олборлон баяжуулна.

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Эм Эс бэл майнинг

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
1	2 ээлжээр	75	18	20

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
